

Цуврал хичээл-4

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монголын хөрөнгийн бирж Монгол Улсын Засгийн Газрын 22 тоот тогтоолоор 1991 оны 1 сарын 18 нд байгуулагдсан.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН БҮТЭЦ.

Стратеги, зах зээлийн хөгжлийн алба

Арилжаа, хяналтын алба

Захиргааны алба

Санхүү төлөвлөлтийн алба

Маркетинг, олон нийттэй харилцах алба

Мэдээлэл технологийн албанаас тус тус бүрдэнэ.

Монголын хөрөнгийн бирж (МХБ) дээр зохион байгуулагдаж буй үнэт цаасны арилжааг хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, шуурхай явуулах, арилжааны мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх үүрэг хүлээдэг. Монголын хөрөнгийн бирж (МХБ) байгуулагдан, Монгол Улсын Үнэт цаасны хороо үйл ажиллагаагаа эхэлсэн 1992 - 1995 онуудад 475 улсын үйлдвэрийн газрыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн хувьцааг нь хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр Монголын ард түмэнд “үнэгүй худалдсанаар” Хөрөнгийн бирж нийт 8.3 тэрбум төгрөгийн арилжаа явуулж, Монгол улсын хүн амын 52 орчим хувь буюу 1.2 сая хүн хувьцаа эзэмшигч болжээ. 1995 оны 8 дугаар сард бэлэн мөнгөний арилжаа буюу хөрөнгийн хоёрдогч зах зээл нээгдсэнээр нэг талаас үнэгүй эзэмшсэн хувьцаагаа бусдад худалдах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгосон бол нөгөө талд тэрхүү хувьцааг нь худалдан авч үйлдвэр аж ахуйн газрын эзэн болох хүсэлтэй этгээдүүдэд энэ зорилгоо хэрэгжүүлэх таатай нөхцөл бүрдсэн юм.

1995-2000 он хүртэлх хугацаанд МХБ дээр нийт 34.2 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа явагдаж, бүрэн хувьчлагдсан компаниудын нийт хувьцааны 73.5 хувь нь ердөө 1304 хувьцаа эзэмшигчийн мэдэлд төвлөрсөн байна. Хөрөнгийн /Үнэт Цаасны/ зах зээл болон санхүүгийн зах зээл дээр олон төрлийн төлбөрийн хэрэгсэл арилжаалагдах замаар сул чөлөөтэй байгаа хөрөнгө эдийн засгийн нэг салбараас санхүүжилт хэрэгтэй байгаа нөгөө салбар уруу шилжиж дахин хуваарилагдаж байдаг.

Хөрөнгийн зах зээлийн гол зорилго бол үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалтаар дэмжиж, хөрөнгө оруулагч иргэд, байгууллагуудын хөрөнгийг өсгөн үндэсний баялаг бүтээх явдал юм.

Оролцогч талуудын хувьд ерөнхийд нь үнэт цаас гаргагчид, хөрөнгө оруулагчид болон мэргэжлийн оролцогчид гэж хуваадаг. Үнэт цаас гаргаснаар үйлдвэрлэгчид, байгууллагууд болон засгийн газар хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зах зээлээс татан төвлөрүүлж үйл ажиллагаагаа өргөжүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээгээ нэмэгдүүлэх, улс орны бүтээн байгуулалтыг хийх, урсгал санхүүжилтүүдийг хийх боломжтой болдог. Монгол улсын “Үнэт цаасны

зах зээлийн тухай” хуульд зааснаар Засгийн газар болон нийслэл, аймаг орон нутгийн удирдах байгууллага болон аж ахуйн нэгжүүд үнэт цаас гаргах эрхтэй. Хөрөнгө оруулагчид Дотоод гадаадын иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд хэн ч хөрөнгө оруулагч байж болох бөгөөд хөрөнгө оруулагч үнэт цаас худалдаж авснаар:

- Ногдол ашиг хүртэх
 - Ханшийн өсөлтөөс ашиг олох
 - Үнэт цаасны хүү авах
 - Компанийн эрх барилцах зэрэг олон төрлийн ашиг олох боломжтой юм. Хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд хэрэглэгддэг зарим нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 - Үнэт цаасны дуудлага арилжаа - Арилжаа хөтлөгч тодорхой үнэт цаасыг үнэ хаялцуулах аргаар арилжих үйл ажиллагаа;
 - Үнэт цаасны үргэлжилсэн дуудлага арилжаа - Үнэт цаасыг эрэлт нийлүүлэлтийн үндсэн дээр арилжих үйл ажиллагаа;
 - Үнэт цаасны багцын арилжаа - Нэг төрлийн болон нийлмэл багцыг худалдан авах буюу худалдах захиалгын дагуу хийгдэх арилжаа;
 - Нээлтийн ханш - Тухайн арилжааны өдөр тухайн үнэт цаасыг арилжсан анхны хэлцлийн ханш;
 - Хаалтын ханш - Тухайн арилжааны өдөр тухайн үнэт цаасыг арилжсан сүүлчийн хэлцлийн ханш;
 - Бонд - Эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг;
 - Өгөөж - Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны бондын буцаан төлөгдөх хүртэлх хугацааны ашгийн хувь хэмжээ;
 - Хэлцэл - Үнэт цаасны арилжааны явцад хэлцлийн жагсаалтад бүртгэгдсэн, төлбөр тооцоо хийгдэхээс өмнөх хугацааны хэлцэл;
- МХБ-ийн арилжаагаар зөвхөн биржид бүртгэлтэй бүх төрлийн үнэт цаасыг арилжина. Арилжаанд зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооноос (СЗХ) үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан, МХБ-ийн гишүүн брокер дилерийн компанийн (БДК) төлөөлөгч (арилжаанд оролцогч) оролцоно.

Санхүүгийн зохицуулах хороо нь үнэт цаас гаргагчдын болон хөрөнгийн зах зээлийн харилцаанд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны зах зээлийн талаар олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх, журам зааварыг хэрэгжүүлж ажилладаг.

Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв нь Монголын хөрөнгийн биржийн бүтцээс төлбөр тооцоо хадгаламжийн албыг тусгаарлан 100 хувь төрийн өмчит “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийг 2003 онд байгуулсан. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэл нь гэрээний үндсэн дээр үнэт цаасны арилжааны гүйлгээний дүнд үүссэн төлбөрийг тодорхойлж, тооцоо хийх үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх болон уг эрхийг бусдад шилжсэнийг бүртгэх, үнэт цаасыг хадгалах үйлчилгээ үзүүлнэ. (www.mse.mn, www.BDSec.mn)

Андерайтер, брокер ба дилерийн компани нь хөрөнгийн зах зээл дээр

Андерайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй. Андерайтерын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэг тэрбум төгрөг байна. МХБ дээр брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх нийт 62 компани 2015 оны эхний улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байна. Брокер, дилерийн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 50 сая төгрөгөөс доошгүй байна. Монголын хөрөнгийн зах зээлд 2001 оноос хойш төгрөгөөр 10 компани бонд гаргаж, доллароор 1 компани бонд гаргаад байна. Эдгээрт:

- “Барилга корпораци” ХК,
- “Нийслэл өргөө” ХК,
- “Пума групп”,
- “MCS” электроникс,
- “Анод банк”,
- “Алтан хот корпораци” ХХК,
- “Говь” ХК,
- “Их барилга төсөл” ХХК,
- “Монинжбар” ХК зэрэг компаниуд байна.